



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/159

Чингис хот

“Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөрийг
хэрэгжүүлэхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ын “а”, 29.1.6-ын “а”, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2017 оны 09 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөрийн хүрээнд Архинд донтох өвчтэй болсон иргэн өөрийн санаачилгаар сайн дурын үндсэн дээр эмчлүүлэх хүсэлт гаргасан иргэдийг эмчилэх зардалд 970000 /есөн зуун далан мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Өөрийн санаачилгаар сайн дурын үндсэн дээр эмчлүүлэх хүсэлт гаргасан иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын “Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /Л.Бат-Октябрь/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2020 оны
03 дугаар сарын 20 өдрийн 107/159
дугаар захирамжийн хавсралт

"АРХИДАЛТГҮЙ ХЭНТИЙ" ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
3 ДУГААР САРД ЭМЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН НЭРС

№	Овог нэр	Зардал	Сум	Хэвтсэн он сар өдөр	Эмчилгээ	Утас
1	Иш Эрдэнэбат	Аймгийн зардлаас 440.0	Хэрлэн сум 1 дүгээр баг	2020.03.17	Хордлого тайлах, спираль	80175238
2	Должинсүрэн Мишигдорж	Аймгийн зардлаас 440.0	Хэрлэн сум 3 дугаар баг	2020.03.17	Хордлого тайлах, спираль	98533533
3	Янжиндулам Баярбат	Аймгийн зардлаас 90.0	Дадал сум	2020.03.16	Хордлого тайлах	98143200
Нийт 970.000						